

ШҮҮМЖ, САНАЛ**“Монгол улсын засаг, захиргааны
зохион байгуулалтын өөрчлөлт,
шинэчлэлт” /1961-1997/ номын тухай**

Ч.БАТЦЭЦЭГ

Монголын Үндэсний архивын газраас эрхлэн ахмад архивч, түүхч Ц.Сономдагва 1961, 1967 онуудад бичиж хэвлүүлсэн Монголын төрийн засаг захиргааны зохион байгуулалт, түүний түүхэн өөрчлөлтийн талаархи хоёр номыг эмхэтгэн улмаар түүхийн эх сурвалж, архивын зарим баримт мэдээ сэлтээр баяжуулан судалгаа лавлагааны чухал бүтээл болох "Монгол Улсын засаг захиргааны зохион байгуулалтын өөрчлөлт, шинэчлэлт" нэртэй ном гаргалаа.

Уг ном Оршил, Тэргүүн хэсэг Монгол улсын засаглал: 1691-1923; Дэд хэсэг Монголын засаг, захиргааны зохион байгуулалт 1923-1997 гэсэн 3 хэсгээс бүрджээ.

XV-XVIII зууны үед Монголын феодалын бутрал, манжийн ноёрхлын улмаас ар, өвөр, ойрад Монголын хүн ам суугуул нутгаасаа дайжин гарч, ойр зуураа нутаг сэлгэн холилдох явдал элбэг байсан бөгөөд тэр үед газар нутгийг өөрчилж аймаг, сум, хошуудыг жижигрүүлэн зохион байгуулалтын ажил хийж байсан юм. Харин XVII зууны хоёрдугаар хагасаас халх, баруун монголын олон ястны байршил тогтворжин тэр байдлаараа XX зууны эхэн хүрчээ. Энэ талаар номын тэргүүн хэсэгт Монгол улсын орон нутгийн засаг захиргааны зохион байгуулалтыг XVI зууны дунд үеэс XVII зууны эцэс хүртэл оршиж байсан Халхын долоон хошуунаас эхлэн Манжийн ноёрхлын үед хийсэн засаг захиргааны нэгжийн зохион байгуулалт, өрх, хүн ам, хөрөнгө, Богд хаант Монгол улсын үед, ардын засгийн анхны жилүүдэд ямар нэртэй, хэдэн сумтай, хэдэн малтай байсан, эдгээр хошуу сумдад байсан овгууд, одоо чухам аль аймагт харъяалагдаж буй зэргийг архивын чухал баримтад тулгуурлан гаргажээ.

Манай монголчууд бүр VIII зуун үеэс овгийг хэрэглэж, удам угсаагаа сайн мэддэг байсан тухай түүхийн сурвалж, судалгааны бүтээлүүд их байдаг, гэтэл түүхэн нөхцөл байдлаас болж эрт удмынхаа түүхийг мэдэхгүй бараг 1921 оны хувьсгалаас хойш л Монгол улс буй болсон мэт эсвэл бүр 1989 оноос өмнөх түүхэн үйл явдлыг үндсээр нь буруутгадаг ойлголт зарим хүмүүст мэр сэр бий болжээ. Угийн бичгийг хөтлөн, овгоо сэргээн хэрэглэх ажлыг төр засгаас онцгой анхаарч байгаа өнөө үед энэ ном хэвлэгдэн гарсан нь өөрсдийн удам угсаагаа мэдэхэд ихээхэн ач холбогдолтой болжээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1991 оны 115 дугаар зарлигт: "Хүн бүр овог удмаа мэдэж, угийн бичгээ хөтлөх үндэсний түүхэн уламжлалыг сэргээн хөгжүүлэхийг Монголын нийт иргэдэд уриалсугай" гээд Монгол улсын засгийн газрын 1997 оны 12 дугаар тогтоолоор "Угийн бичиг хөтлөх" журмыг баталсан юм. Үүнд: "Монгол улсын иргэн бүр овогтой байна, овгийг эцгийн шугам буюу нэр, өөрийн нэрийг иргэний паспорт, гадаад паспорт, төрсний гэрчилгээ, гэр бүлийн бүртгэлд бичнэ, угийн бичгийг Монгол улсын өрх бүрхөтөлнө, угийн бичигт тухайн хүний мэдэх өвөг дээдсээсээ эхлэн өөрийн хүүхэд хүртэлх ясан болон цусан төрлийн ураг садан хүмүүсийг тус бүрээр нь тодорхойлон бичнэ гэжээ. Ийнхүү уг журам өнөөдөр бодит ажил болж эхлээд байна. Уг номд аль аймгийн ямар сумдад ямар ямар овог байсныг архивын баримт, түүхийн сурвалж бичгүүдийг үндэслэн гаргаж тавьснаар иргэд өөрсдийн овгийг тодорхойлон хэрэглэхэд хялбар дөхөм болжээ.

Мөн тухайн хошуу нутагтай холбогдох түүхийн баримт, сүм хийд, хошуудын ноёдын удам угсаа залгамжлал, хэргэм зэр хилийн цэсийг товч боловч тодорхой "Чухундоржоос Манжийн хаанд айлтгасан нь: Бидний улсад анхандаа Бурхан шашин үгүй бүлгээ. Миний элэнц өвөг Автай хан Далай лам одож бараалхаад ихэд хүндэтгэгдэн Очирбат сайн хан цолыг хүртэв. Түүнээс хойш манай газарт бурхны шашны наран мэт гэрэлтэх болов" хэмээсэн нь буй /15 дахь тал/ гэх зэргээр тусгасан нь 1929-1940 онуудад устгагдсан 700-гаад сүм хийд хаана аль нутагт оршиж үйл ажиллагаагаа явуулж байсан, лам хуврагын хэлмэгдүүлэлтийн талаар мэдэж авахад онцгой хувь нэмэр оруулж, уул бүтээлийн үнэ цэнийг нэмэгдүүлж байгаа нь дамжиггүй.

Монголчууд эрт дээр үеэс хууль ёсыг чанд сахиж байсныг бид бүхэн сайн мэдэх билээ, энэ талаар нэлээд баримт дурьджээ.

Тухайлбал Цогтой гүний хошууны Дамдин туслагч чулуун нүүрс, алт, давс олдворлох, тарвага зээр агнах зэргээр дур зоргоор аашилж, Монгол нутгийн баялагт шунахайран явсан хятад иргэдийг тодорхой хугацаа болзоо тогтоон хөөн зайлуулж байв. 196 дахь тал гэх юмуу манай Монголчуудын ёсонд эрийн гурван наадам хийхээс гадна айл гэрийн дотор хорол, шагай, үүчүүр мэт цөөн тоглоомоор хүүхэд залуучуудыг тоглуулж байв. Даалуу мэт хонжворт тоглоомыг хатуу хориглож байжээ. Тус хошууны засаг бэйл Дэлэгпунцаг 1815 онд олон отог багийн дарга нарт тушаасан бичигтээ: "Одоо цагт Хятадын мужуудаас Өвөр Монголын Түмэд хошуугаар дамжиж ирсэн "Ү пэй вэй" хэмээх хонжворт тоглоом манай Халхын Их Хүрээ Мэт газарт иргэн Хятадын дунд дэлгэрч буй гэх чимээ буй тул энэ мэт гажуу суртлын тоглоомоор наадан зугаацагчид манай хошуунд гарваас монголчуудын Номхон шулуун зан суртлын эвдэх тул хатуу хоригловоос зохино. Хэрэв ийм тоглоомоор тоглогчид байх болбоос баривчлан авч Тамгын газар хүргэн ирүүлж чангалан шийтгүүлсүгэй" хэмээн тушааж байжээ. /т.183/ гэх мэтээр олон жишээ баримт дурьдсан нь цаг үеэ олсон, ач холбогдлоо алдаагүй

харин ч үүнийг эргэж харахад хэрэгтэй чухал зүйл болжээ.

Номын дэд хэсэгт 1923-1997 оны хоорондох үеийн Монгол улсын 21 аймаг, хот, сум, дүүргийн засаг захиргааны байгууллагын үүсэл, баг, хороо, хорин байгуулагдсан болон татан буугдсан, хөдөө аж ахуйн нэгдэл, сангийн аж ахуй байгуулагдсан улмаар 90-ээд оноос хувьчлан тараасан, аймаг сумдын өрх, хүн ам, мал сүргийн тоо толгойг 1933 оноор, мөнгөн орлого, үндсэн хөрөнгийн байдлыг 1918 оноор гаргаж үзүүлсэн байна.

Улаанбаатар хотын үүсэл өргөжилт, нэрийн өөрчлөлтийг он оноор нь жагсааж, өдгөө нийслэл хот болсон түүхийг товч тусгасан болохоор 360 жилийн ойгоо тэмдэглэх гэж буй өнөө үед хотын иргэд энэ номыг уншаад Нийслэлийнхээ тухай ерөнхий мэдлэг олж авах нь мэдээж.

Манай улсын Хөвсгөл, Төв, Булган, Сэлэнгэ, Хэнтий, Дорнод аймгийн нутагт оршин суудаг буриад, хамниган "Ховд хязгаарын хотон ястнуудын талаар тоймтой тодорхой зүйл олоогүйдээ хүлцэл өчсөн байна. Чухамхүү энэ тухай судалгааны сурвалж баримтуудыг гаргаж олны хүртээл болгосон болхэрэгтэй байжээ. Хэдийгээр түүхч, угсаатны зүйчдийн бүтээлүүдэд дээр дурьдсан ястан угсаатны талаар хийсэн судалгааны ном нийтэд гарсан боловч тэдгээр номууд худалдаанд нэгэнт ховордож. Тэр болгон олдохгүй болжээ. Харин Ховд, Хөвсгөл хязгаарын дархад, урианхай, дөрвөд, баяд, Торгууд, захчин, өөлд, Мянгад Алтайн 7 хошуу, урианхай, казах зэрэг олон ястны нүүдэл, суурьшил, хошуу, сум болсон түүх, манж нарт төлж байсан алба татвар, тэдний эсрэг хийж байсан тэмцэл, 1911-12 онуудын үндэсний хувьсгалтай холбогдох чухал баримтуудыг номд оруулахыг хичээсэн нь уул бүтээлийн үнэ цэнийг нэмэгдүүлж байна.

"Монгол улсын засаг захиргааны зохион байгуулалтын өөрчлөлт шинэчлэлт" номондоо Манжийн ноёрхлыг түлхэн унагааж, үндэсний тусгаар тогтнолоо сэргээхийн төлөө тэмцлийг удирдаж байсан монголын ард түмний үндэсний баатруудын үйл ажиллагаа, гавъяа зүтгэлийн тухай архивын сан хөмрөгийн шинэ баримтаар баяжуулсан явдал манай залуучуудын мэдлэгийн хүрээг тэлж, эх орон, нутаг усаа хайрлан хамгаалах сэтгэлд их хувь нэмэр оруулна гэдэгт итгэж байна.

Уг номондоо архивын материалаас гадна 1960-аад оноос хойш арван найман аймаг, хотын ойд зориулсан танилцуулга, товч түүхийн номуудаас ашигласан байна.

Эцэст нь хэлэхэд "Монгол улсын засаг захиргааны зохион байгуулалтын өөрчлөлт, шинэчлэлт" энэхүү ном техник үг үсгийн талаар нэлээд их алдаатай, ялангуяа бүхэл бүтэн хоёр хуудас орхигдуулж хэвлэсэн нь хэдийгээр залруулга хийсэн ч уншихад ихээхэн төвөгтэй болгожээ. Мөн бараг хүн бүхний мэдэх мэдээжийн нэрийг буруу бичээд, залруулгадаа оруулаагүй зүйл ихээхэн ажиглагдлаа. Тухайлбал: Хятадын сонгодог уран зохиол "Жин Пин Мэй"-г "Жин орин мэй" /237 т./, нэрт жуулчин, угсаатны зүйч Г.Е.Грумм Гржиймайло-г Г.Е. Грумм-Грээсэгмайло /387 т./казак-казах г.м үг үсгийн

алдаа маш олон байна. Үүнийг цаашид анхаарвал зохилтой. Гэхдээ хэвлэлийн алдаа зэрэг зарим дутагдал нь номын үнэ цэнийг өчүүхэн ч бууруулахгүй гэдэгт эргэлзэхгүй байна.

**Хятад үгийг монголд хэлэнд зөв
галиглах тухай хэдэн үг**

Ш.БАДРААБАТ

Амархан сайн байна уу? Батбаяр гуай! Үл таних боловч захидал бичин чилээж таны үнэт цагаас хороосон явдалд уучлал эрэн мэндчилье! Түшээт ханы дайчин бэйсийн хошуу нутагтай, Бээжингийн их сургуулийн түүхийн I ангийн оюутан Бадраабат танд ёсолсон болно.

Хятад судлалын томоохон төвийн захиралтанд хандан сэдхил зовж явдаг нэгэн зүйлээ "Арга билэг"-т гарсныг хэвлэгдээгүй хавсралтын хамт явуулав. Үүнийг үзээд бодсон санаснаа бичвэл мулгуу оюутан би ихэд баярлана. Яавал энэ асуудлыг цэгцлэх вэ гэдгийг би бодоод олохгүй юм. Мэргэн ах та тунгаана бизээ! Жамсран түүхч шал өмнөө саналтай байдаг юм. Орос галиг нь Монгол галиглалд нэлээд зөрүүтэй билээ. (хавсралтаас үзмүү!) Г.Сүхбаатар доктор дэмждэг боловч өөрөө бас л буруу галигладаг Жишээ нь: Роу рань гэж үг байхыг жужань, Жоу жань гэх мэт буруу галигаар галиглаад түүнээсээ "нирун" гэдэг үгээ гаргаж байгаа юм. Яаж ч бодсон ингэж гарах ёсгүй юм. Хүсвэл роу рань-Нирун гэсэн зохиомж байж болох. За гэвч мэдэхгүй юм.

Үүний тухай ёсолсон Бадраабат

Өгүүлэх ину:

Хүн төрөлхтний соёл иргэншлийн түүх хэдэн мянган жилээр хэмжигдэх болсон өнөө үед Монголчууд бид эртний уламжлалт түүх соёлын олон чухал асуудлаа эргэн нягталж, бодит түүхэн үнэнээр сэргээхийг оролдож буй нь нэн сайшаалтай. Сүүлийн үед манай түүхч, эрдэмтэд, хятад судлаачид түүх бичлэгээ сэргээх үүднээс эртнээс түүх, соёлын өргөн харилцаатай явж ирсэн Монгол, Хятадын эрт эдүгээгийн түүхийн баримт сэлтийг улам нягтлан судлах боллоо.

Үүнтэй уялдан миний бие, хятад үгийг монголд хэлэнд зөв галиглах асуудлыг хөндөн санал солилцохоор шийдсэн билээ. Учир нь Хятадтай холбогдох бүхий л судалгаа сурталчилгааны бүтээлд бид Хятад үгийг маш олон янзаар галигласаар ирсэн бөгөөд одоо ч мөн энэ байдал үргэлжилсээр байна. Угтаа, нэн эртнээс бичиг үсгийн соёлтой Монголчууд бидэнд ямар ч гадаад үгийг эх хэлэндээ илүү дөхөм буулгах нь тийм ч хүндрэлтэй бус санагдана.